



**МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ
УХААН, СПОРТЫН ЯАМ**

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Бага тойруу 44, Засгийн газрын III байр,
Утас: 26-22-27, Факс: (976-11) 32-35-89,
E-mail: info@mecss.gov.mn, http:www.mecss.gov.mn

2020. 01. 31 № 2/633
танай _____-ны № _____-т

**АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮН КОМИССАР
З.ДАШДАВАА ТАНАА**

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 114 тогтоолын хавсралтаар баталсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний 2019 оны хэрэгжилтийн тайланг хавсралтаар, нотлох баримтын хамт хүргүүлж байна.

Хүлээн авч танилцана уу.

Хавсралт хуудас

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ГҮЙЦЭТГЭГЧ, ХУУЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА *Цэдэвсүрэн* ЦЭДЭВСҮРЭН



1420100771

**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН ЯАМНЫ АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ
ХӨТӨЛБӨРИЙН 2019 ОНЫ ТАЙЛАН**

2020.01.30

Үндэсний тусгагдсан ажиллагаа	хөтөлбөрт үйл	Үйл хэрэгжүүлэх хэмжээ	ажиллагааг арга	Хэрэгжих хугацаа	Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт
1	4.1.1.1. төрийн албаны төв байгууллагын дүгнэлт, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянасан байдлыг үндэслэн албан тушаалд томилох тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хариуцлагыг дээшлүүлэх	Төрийн албаны зөвлөлийн болон салбар зөвлөлийн дүгнэлт, нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг(ХАСУМ)-ийг хянасан дүгнэлтийг олон нийтэд ил тод, нээлттэй болгох	2017-2022	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Дээд боловсролын бодлогын газрын, Сургуулийн өмнөх боловсролын бодлогын газрын, Төрийн захиргааны удирдлагын газрын, Гадаад хамтын ажиллагааны газрын, Санхүү, хөрөнө оруулалтын газрын, Инновацийн хэлтсийн, Мэдээллийн технологи, статистикийн хэлтсийн даргын албан тушаалд Төрийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3 дахь хэсэгт заасан шалгуурын дагуу тусгай шалгалт явуулах шалгаруулалтыг тус тус зохион байгуулуулах захиалгыг Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн. Төрийн албаны зөвлөл тус яамны Төрийн захиргааны удирдлагын газрын, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын даргын ажлын байранд тусгай шалгалтыг зохион байгуулж, Төрийн захиргааны удирдлагын газрын даргын албан тушаалд О.Хуягцогтыг томилуулахаар Төрийн албаны зөвлөлийн 2019 оны “Нэр дэвшүүлж, санал болгох тухай” 86 дугаар тогтоолыг ирүүлсэн. Тогтоолыг үндэслэн Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны “Огноогийн Хуягцогтыг ажилд томилох тухай” Б/158 дугаар	

тушаалаар Төрийн захиргааны удирдлагын газрын даргаар О.Хуягцогтыг томилсон.

Харьяа байгууллагын төсвийн шууд захирагчийн сул ажлын байрны сонгон шалгаруулалтыг 2019 оны Төрийн албаны зөвлөлтэй хамтран 2 удаа зохион байгуулж, 16 иргэн сонгон шалгаруулалтад тэнцсэн. 11 иргэний албан тушаалд томилон ажиллуулсан. 4 иргэний урьдчилсан мэдүүлгийг хянуулахаар Авлигатай тэмцэх газарт хүргүүлээд байна. Богд хааны ордон музейн захирлын албан тушаалын сонгон шалгаруулалтад тэнцсэн иргэнийг одоогоор албан тушаалд томилоогүй байна.

Төрийн жинхэнэ албан хаагчийн шалгалт өгч нөөцөд бүртгэгдэн, Төрийн албаны зөвлөлөөс нэр дэвшүүлсэн иргэнийг хууль тогтоомжид нийцүүлэн туршилтаар ажиллуулж, туршилтын хугацаа дууссан тул 4 албан хаагчийг тангараг өргүүлсэн.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны сул ажлын байранд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл урлагийн газар болон төрийн бусад байгууллагаас Төрийн албаны тухай хуулийн 44.1 дэх хэсгийг үндэслэл болгон 4 албан хаагчийн томилон ажиллуулав. Нийтийн албанд томилогдохоор /Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам болон салбарын хэмжээнд/ 2019 онд нэр дэвшсэн нийт 48 албан хаагчийн Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг (ХАСУМ)-ийг Авлигатай тэмцэх газарт хүргүүлж, Хувийн ашиг сонирхолын урьдчилсан мэдүүлгийг хянуулж, дүгнэлтийг авсан.

3	<p>4.1.1.2.нийтийн албанд томилогдох албан тушаалтны ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын шалгуурыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх, албан тушаалтныг мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг баримтлан томилох, дэвшүүлэх</p>	<p>Албан тушаалтанд тавигдах ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын ерөнхий болон тусгай шалгуурыг үндэслэн төрийн албанд томилох, дэвшүүлэх тогтолцоог бүрдүүлэх</p>	2017-2022	<p>Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны А/31 дүгээр тушаалаар “Ажлын байрны нэр, тодорхойлолтод шинжилгээ хийх, дүгнэлт санал гаргах” ажлын хэсгийг байгуулж ажилласан. Ажлын хэсэг Төрийн албаны тухай шинэчилсэн хууль, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 02, 03 дугаар тогтоолыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллалаа. Ажлын хэсэг нь яамны үйл ажиллагаанд илэрч байгаа зарим ажлын байрны ажлын ачаалал, чиг үүргийн давхардал, хийдлийг тодорхойлж, албан тушаалын тодорхойлолтыг боловсруулах чиглэлээр тодорхой санал гарган, ажлын хэсгийн дүгнэлт саналыг үндэслэн ажлын байрны нэр, ангилал зэрэглэлийг шинэчлэн тогтоож, албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан. Албан тушаалын тодорхойлолтын төслийг тус яамны Салбар зөвлөлийн хурлаар хэлэлцэн дүгнэлт гаргаж, зөвшөөрөл авахаар Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн. Тус яамны 14 газар, хэлтсийн даргын албан тушаалын тодорхойлолтын төслийг зөвшөөрсөн Төрийн албаны зөвлөлийн 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 46 дугаар тогтоолыг үндэслэн Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны “ Албан тушаалын тодорхойлолт батлах тухай” Б/127 дугаар тушаалаар батлаж, мөрдөн ажиллаж байна. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарын хүрээнд хууль тогтоомжоор хэрэгжүүлэх үйл ажиллагаанд чиг үүргийн шинжилгээг 2019 онд хийсэн. Засгийн газрын 2018 оны 22 дугаар тогтоолоор батлагдсан “Чиг үүрэг дахин хуваарилах аргачлал”, Засгийн</p>
---	--	---	-----------	---

				<p>газрын хуралдааны 2019 оны 2 дугаар тэмдэглэлийг хэрэгжүүлэх зорилгоор Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарын чиг үүргийн шинжилгээ хийх, дахин хуваарилах санал боловсруулах үүрэг бүхий техникийн ажлын хэсгийг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн "Ажлын хэсэг байгуулах тухай" А/65 дугаар тушаалаар байгуулан ажилласан.</p> <p>Мөн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны 5 дугаар сарын 01-ний өдрийн "Дэд ажлын хэсэг байгуулах тухай" А/99 дүгээр тушаалаар техникийн ажлын хэсэгт шаардлагатай баримт бичгийг бүрдүүлэн танилцуулах, мэдээллээр хангах дэд ажлын хэсгийг байгуулсан. Дэд ажлын хэсгийн хүрээнд Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамнаас төрийн бус болон хувийн хэвшлийн байгууллагад шилжүүлэн хэрэгжүүлж байгаа чиг үүрэг, гүйцэтгүүлж буй ажлын мэдээллийг судлан дүгнэлт гаргасан. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарын хүрээнд хууль тогтоомжоор хэрэгжүүлэх үйл ажиллагаанд чиг үүргийн дүн шинжилгээ, судалгааны дүгнэлтийг Засгийн газрын дэд ажлын хэсэгт танилцуулсан.</p> <p>Шинээр батлагдсан ёс зүйн дүрмийг яамны дотоод сүлжээнд байршуулж, яамны албан хаагчдад танилцуулсан. Тус яамны дэргэдэх Ёс зүйн зөвлөлийг хууль тогтоомжийн дагуу яам, агентлагийн албан хаагчдаас санал авч хамгийн их санал авсан албан хаагчдаар бүрдүүлэн Төрийн албан зөвлөлийн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны дэргэдэх</p>
--	--	--	--	---

<p>Салбар зөвлөлийн 2019 оны “Ёс зүйн зөвлөл байгуулах тухай” 02 дугаар тогтоолоор байгуулсан. Салбар зөвлөлийн 2019 оны “Ёс зүйн зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” 07 дугаар тогтоолоор Ёс зүйн зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулсан. Ёс зүйн зөвлөл 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан дараах ажлыг хэрэгжүүлж ажиллалаа.</p> <p>Үүнд:</p> <p>-2019 оныг “Ёс зүйн боловсролын жил” болгон зарлаж тодорхой ажлыг үе шаттайгаар зохион байгуулж ажиллалаа. Энэ хүрээнд боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарын удирдах ажилтны зөвлөгөөнийг зохион байгуулж, салбарын албан хаагчдад хандсан уриалга, зөвлөмж гаргасан. Зөвлөгөөний шийдвэрийг хэрэгжүүлэх ажлын дэд хэсгүүдийг байгуулж ажиллаж байна.</p> <p>-Төрийн албаны хууль, Ёс зүйн зарчим, ёс зүйн боловсролтой холбоотой зурагт хуудас, номын хавчуурга, тэмдэглэлийн дэвтэр хэвлүүлэн яам, агентлагийн албан хаагчдад түгээх, мэдээллийн самбар болон хурлын ерөөнд байрлуулаад байна. /Хавсралт-1/</p> <p>-Яам, агентлагийн удирдлага, албан хаагчдад Төрийн албаны шинэчилсэн хууль, тогтоомж, ёс зүйн шинэ дүрмийн талаар 2019 оны 6 сард сургалт зохион байгуулсан.</p> <p>-Яам, агентлагын ёс зүйн зөрчил, авлигад өртөж болзошгүй ажлын байрны судалгаа гарган, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч, соён гэгээрүүлэх сургалтыг 2019 оны 5, 10 дугаар сард зохион байгуулсан.</p> <p>-Яамны албан хаагчид, их дээд сургуулийн багш, оюунтнуудад ёс зүйн сургалтыг 2019 оны</p>			
---	--	--	--

4	4.1.1.7.нийтийн албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой гомдол, мэдээллийг хүлээн авах, хянан шалгах, хариуцлага хүлээлгэх арга хэлбэрийг тодорхой болгож, дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх	Албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авах, хянан шалгах, хариуцлага хүлээлгэх үйл ажиллагааг шинэ арга хэлбэрт шилжүүлэх, дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх			12 сард АНУ-ын эрдэмтэн багшийг урьж зохион байгууллаа. Яамны хөдөлмөрийн дотоод журам, холбогдох бусад журам, гэрээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөнд ёс зүйн зарчмын талаар тодорхой заалт тусган батлаж, мөрдөн ажиллаж байна.
			2017-2019		Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны дэргэдэх Ёс зүйн зөвлөлийг 2019 онд холбогдох хууль, дүрмийг үндэслэл болгон яам, агентлагийн албан хаагчдаас санал авч байгуулсан. 2019 онд Ёс зүйн зөвлөлд 6 гомдол ирж, хууль тогтоомжийн дагуу судлан шийдвэрлэсэн. Зөвлөлийн хурлыг 6 удаа хуралдаж, зөвлөлийн төлөвлөгөө, түүний хэрэгжилт, ирсэн гомдолтой холбоотой асуудлаар албан хаагч, иргэдээс тодруулга мэдээллийг авч ажилласан. Тус яамны нэг албан хаагчид Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар сахилгын арга хэмжээ авсан /хавсаргав/. Хоёр албан хаагчид ёс зүйн зөрчил гаргасан талаарх дүгнэлтийг гаргаж танилцуулсан. -Төрийн албаны зөвлөлийн баталсан журмын дагуу яамны албан хаагчдын хувийн хэрэг шинэчлэх ажлыг зохион байгуулж, ажиллалаа. -Яам, харьяа байгууллагын албан хаагчдад Төрийн албаны шинэчилсэн хууль, Ёс зүйн дүрмийг судлуулах түгээн дэлгэрүүлэх, мөрдөн ажиллахад дэмжлэг үзүүлэх зорилгоор Төрийн албаны зөвлөл, Хууль зүйн үндэсний хүрээлэн, Удирдлагын академи, Аксел фишер академитай хамтран сургалт зохион байгуулж, албан хаагчдад мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлсэн. Мөн Төрийн албаны тухай шинэчилсэн хуулийн

гарын авлагыг нийт албан хаагчдын ажлын хэрэгцээнд зориулан авч өгсөн.

-Салбар зөвлөлөөс Засгийн газрын агентлаг Биеийн тамир, спортын газар, Соёл урлагийн газарт дараах чиглэлээр зөвлөмж, чиглэл, даалгавар өгч ажилласан. Үүнд:

1.Төрийн албаны шинэчилсэн хууль, түүнийг дагаж гарсан журам, дүрмийг нийт албан хаагчиддаа судлуулах, сургалт зохион байгуулах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллах,

2.Албан хаагчдын хувийн хэргийг журмын дагуу шинэчлэх,

3.Сул орон тооны судалгааг ирүүлэх,

4.Ёс зүйн зөвлөлд төлөөлөл оруулах талаар санал ирүүлэх,

5.Эрхэлсэн, ахлах түшмэлийн багц сургалтад зарим албан хаагчдыг хамруулах,

6.Албан тушаалын тодорхойлолт боловсруулах талаар зөвлөмж өгч, Төрийн албаны зөвлөлд хүргэж хянуулах чиглэлийг өгч ажиллалаа.

Өргөдөл, гомдол, мэдээллийг хянан шалгах ёс зүйн хороо, хяналт шалгалт, дотоод аудитын нэгжийн үйл ажиллагааны үр дүн сайжирсан.

2. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг сайжруулах, баримт бичгийн цахим санг тасралтгүй нэмэгдүүлэх, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаа, зохион байгуулалт, иргэдэд шуурхай, үйлчилгээ үзүүлэх зорилтын хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

Тус яаманд 2019 онд хандаж ирүүлсэн нийт албан бичиг 14574, өргөдөл гомдол 3685 хүлээн авч бүртгэн, иргэд, албан байгууллагаас ирүүлсэн хариутай албан бичиг, өргөдөл гомдлын тайланг гаргаж, шийдвэрлэгдээгүй хугацаа хэтэрсэн өргөдөл, гомдол, албан бичгийн дэлгэрэнгүй болон шийдвэрлэлтийн талаарх мэдээллийг 14 хоног тутам гарган, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, дэд сайд, Төрийн нарийн бичгийн дарга, газар, хэлтсийн дарга, албан хаагчдад цахим хэлбэрээр мэдээлж, сайд, төрийн нарийн бичгийн даргын шуурхай хуралдаанд 7 хоног бүрийн даваа гарагт танилцуулж, шийдвэрлэлтийн байдалд хяналт тавин ажиллалаа.

2019 онд нийт ирсэн, явсан бичгийн эргэлтийн тоо:

Бичгээр ирсэн албан бичиг, өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн тоо 18259, хариутай бичгийн тоо 10880, хариугүй шууд бичгийн тоо 3694, захидал, хүсэлт, өргөдөл, гомдол 3685, явуулсан бичиг 10855 албан бичгийг хүргүүлсэн байна.

- 2019 онд яаманд хандаж иргэд, албан байгууллагаас ирүүлсэн албан бичгийн тоог өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад албан бичиг 5.5%-аар нэмэгдсэн бол өргөдөл, гомдол 2 дахин буурсан үзүүлэлттэй байна. Иргэд,

албан байгууллагад явуулсан бичгийн тоо мөн буурсан үзүүлэлттэй байгаа нь энэ талаар авсан арга хэмжээ бодитой үр дүнд хүрснийг харуулж байна.

БСШУСЯ-нд ирсэн баримт бичгийг ангилж, өмнөх онуудын мөн үеийнхтэй харьцуулан, тоо болон графикаар үзүүлбэл:

№	Он	2017		2018	
		Тоо	Хувь	Тоо	Хувь
1	Хариутай бичиг	4992	31.9%	10744	52.5%
2	Өргөдөл, гомдол, захидал	5117	32.8%	6350	31.1%
3	Шууд бичиг	5508	35.3%	3353	16.4%
	Дүн	15617	100%	20447	100%


Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим санд Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны чиг үүрэгт хамаарах 200 хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт урьдчилсан үнэлгээгээр 90.2 хувьтай байна. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Төрийн нарийн бичгийн даргын “Хууль тогтоомж, тогтоомжийн хэрэгжилтийг

2017-2022

Төрийн байгууллагуудын албан хэрэг хөтлөлтийн системүүдтэй нийтийн түлхүүрийн дэд бүтцийг холбох

4.1.1.9. төрийн байгууллага хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлж, мэдээлэл солилцох нөхцөл, боломжийг сайжруулах

5

				<p>эрчимжүүлэх тухай” 2019 оны А/205 дугаар тушаалаар хэрэгжилтийг эрчимжүүлэх, шуурхайлах чиглэл өгч ажиллаа.</p> <p>УИХ, Засгийн газраас гаргасан хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийг Able програмд бүртгэн карталж, нийт албан хаагчдын албан хэрэгцээнд зориулан байршуулж, цахим санг бүрдүүлэн ажиллаж байна. 2019 онд нийт 118 тогтоол шийдвэрийг байршуулсан байна.</p> <p>Able системд байршуулсан тогтоол, шийдвэр /2019 он/</p>  <p>Ерөнхийлөгчийн УИХ-ын БХ-ны УИХ-ын даргын Засгийн газрын хуралдааны тэмдэглэл зарлиг тогтоол захирамж тогтоол</p>
6	4.1.1.10.нийтийн албаны сургалтын институт байгуулах, тушаалтныг сургах бүрдүүлэх	Төрийн албаны бүх чиглэлээр хугацааны болон давтан явуулах нийтийн албаны сургалтын институт байгуулах	2017-2019	<p>-Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орж, хүчин төгөлдөр үйлчилж эхлэх гэж байгаатай холбогдуулан яамны нийт албан хаагч, харьяа байгууллагын удирдлага нарт тус хуулийн хэрэглээ бусад анхаарах асуудлаар сургалт-мэдээллийг 2019 оны 05 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулсан. Тус сургалтад яамны нийт албан хаагчдаас 85 албан хаагч, харьяа байгууллагын 102 удирдлага, нягтлан бодогч нар бүрэн хамрагдсан.</p> <p>Сургалтад Сангийн яам, Азийн хөгжлийн банкны төлөөлөгч нар холбогдох хууль</p>

тогтоомжид орсон өөрчлөлт, худалдан авах үйл ажиллагаанд анхаарах асуудлын талаар мэдээллийг өгч ач холбогдол бүхий сургалт болсон гэж үзэж байна.

Төрийн албаны тухай хууль, хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд дагаж гарсан дүрэм, журмыг яамны албан хаагчдад хууль, Улсын Их Хурлын тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, Төрийн албаны зөвлөлийн тогтоол гэсэн бүлгүүдээр албан хаагчдад танилцуулсан.

Яамны нийт албан хаагчид Захиргааны ерөнхий хуулийн дагуу мэдлэг олгох талаар “Захиргааны байгууллагын ойлголт”, “Захиргааны байгууллагын шийдвэр гаргах ажиллагаа” сэдэвт хичээлүүдийг цахим хэлбэрээр хүргүүлсэн.

Төрийн албаны ёс зүйн сэдэвт сургалтыг “Акселфишер академи” ХХК-тай хамтран яамны албан хаагчдад зохион байгуулсан.

Яамны албан хаагчдад төрийн албаны хууль тогтоомж, салбарын хууль тогтоомжийн талаар тасралтгүй зөвлөгөө өгч баримт бичгийг хянаж, боловсруулалтыг сайжруулж байгаа нь ажлын байранд дахь тасралтгүй сургалтын хэлбэр юм. Албан хаагчдад Төрийн албаны тухай хуулийг таниулсан хэлбэрээр “Төрийн албаны шинэтгэл” дэвтэр хэвлүүлэн түгээсэн нь ихээхэн ач холбогдолтой болсон гэж үзэж байна.

Монгол Улсын Боловсролын салбарын эрх зүйн орчинг боловсронгуй болгох, Төрийн өмчийн их сургууль, боловсролын байгууллагын эрх зүйн асуудал хариуцсан албан хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор Холбооны Бүгд Найрамдах Герман Улсад 2019 оны 12 дугаар

7	4.1.1.10.нийтийн албаны сургалтын институт байгуулах, албан тушаалтныг даван сургах боломжийг бүрдүүлэх	Авлигын сургалт, сургалтыг эсрэг давтан зохион байгуулах. Үүнд:	2018-2022	сарын 14-нөөс 21-ний өдрүүдэд “Захиргааны байгууллага, захиргааны байгууллагын шийдвэр гаргах үйл ажиллагаа, Олон улсын туршлага” сэдэвт 7 хоногийн сургалтыг зохион байгуулав. Сургалтад харьяа байгууллагын нийт 11 албан хаагч хамрагдсан бөгөөд сургалтын үр дүнд нийтийн ашиг сонирхолыг илэрхийлэн засагласан шийдвэр гаргадаг захиргааны байгууллагууд тэдгээрийн шийдвэр гаргах үйл ажиллагаа, захиргааны акт, захиргааны гэрээ, захиргааны хэм хэмжээний актын талаарх практик мэдлэг үр чадвараа дээшлүүлж, энэ чиглэлийн үйл ажиллагаа явуулж буй Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Мюнхен хотын Ханнс Зайделийн сан, Бавар мужийн Боловсролын яам, Хотын захиргаа-Хуулийн хэлтэс, “Ludwig Maximilian”- ний Их сургуулийн дотоод үйл ажиллагаа тэдгээрийн шийдвэр гаргах процесс ажиллагаатай танилцан, практик туршлага солилцсон.
				Авлигатай тэмцэх газрын Олон нийтийн төвд зохион байгуулагдаж буй авлигын эсрэг бүртгэлд цахим системийг ашигладаг болсонтой холбогдуулан сургалтанд хамрагдан зохион байгуулж буй сургалтанд Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны албан хаагчид болон харьяа байгууллагын 92 албан хаагчийг хамруулсан байгаа болно. Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн 3 төрлийн /ХАУСМ, ХАСХОМ, “Ашиг сонирхлын зөрчилөөс хэрхэн сэргийлэх” болон анхаарах асуудлаар гэсэн сэдэвтэй видео шторкийг яамны цахим санд болон харьяа байгууллагын ЭБАТ нараар

дамжуулан мэдээллийн цахим санд нь байршуулсан.

ХАС, ХОМ, ХАСУМ хэрхэн үнэн зөв мэдүүлэх, албан хаагчдын эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, ажлын хүрээнд Авлигатай тэмцэх газрын Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсийн Мэдүүлгийн бүрдүүлэлт, дүн шинжилгээний албаны дарга, Ахлах комиссар Ц.Цэцэгдэлгэрэх, н.Энхтуяа, н.Баасандэлгэр нартай 2019 оны ХАСХОМ гаргах ажлын бэлтгэл хангах, анхаарах зүйл, тулгамдаж буй асуудлууд, Улсын Их Хурлын Хууль зүйн байнгийн хорооны баталсан 2014 оны 20 дугаар тогтоол, мэдүүлэгийн цахим сангийн талаар Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны харъяа байгууллагын 12 ЭБАТ-ыг хамруулан, уулзалтыг зохион байгуулж, санал солилцсон.

Яамны нийт албан хаагчдад сургалтын мэдээлэл, гарын авлагыг албаны цахим хаягаар тогтмол хүргэн танилцуулж байна.

Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийн “3.1.1.б. хууль зөрчсөн, авлига авсан, албан тушаалын байдлаа урвуулан ашигласан аливаа үйлдэлтэй эвлэршгүй байж, энэ тухай эрх бүхий байгууллага, албан тушаалтанд мэдээлэх” ёс зүйн шаардлагыг биелүүлэх, байгууллагын зорилт, чиг үүргийг хэрэгжүүлж, төрийн үйлчилгээ үзүүлэхдээ ямар нэг ёс зүйн алдаа гаргахгүй байхыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, Төрийн нарийн бичгийн даргаас үүрэг, чиглэлийг нийт албан хаагчдад өгсөн.

9	<p>4.1.2.1.төрийн үйлчилгээг иргэнд цахим хэлбэрээр хүргэх тогтолцоог бүрдүүлэн, цахим үйлчилгээний нэгдсэн сүлжээ бий болгож, бэхжүүлэх</p>	<p>Төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэхэд учрах хүндрэл бэрхшээл, шийдвэрлэх арга замыг судалж, цахим хэлбэрт шилжүүлэх төрийн үйлчилгээний жагсаалтыг шинэчлэн батлуулах</p>	2017-2018	<p>“Боловсролын салбарын мэдээллийн систем”-ийн ажлын хүрээнд Дээд боловсролын салбарт Дээд боловсролын удирдлага мэдээллийн систем /ДБУМС/ нэвтрүүлж, Сургуулийн өмнөх боловсролын байгууллага, ерөнхий боловсролын байгууллагын зарим модулийг шинэчлэн, ерөнхий боловсролын сургуулийн түвшинд Боловсролын бичиг баримт хэвлэх систем, цахим журналын системийг шинээр нэвтрүүлсэн бөгөөд боловсролын баримт бичгийн лавлагааг /суурь, бүрэн дунд боловсролын гэрчилгээ, үнэмлэх 2019 оны төгсөлтийн /ГҮЦ/ машинаас олгож эхлээд байна.</p> <p>Засгийн газрын 2018 оны “Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэх зарим арга хэмжээний тухай” 259 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтын 4 дүгээрт Их, дээд сургууль, ерөнхий боловсролын сургууль төгсөгчийн лавлагааг цахим хэлбэрт шилжүүлнэ гэж заасан байдаг. Тус ажлын хүрээнд Боловсрол, соёл, шинжлэх ухаан спортын сайдын 2018 оны А/286 тоот тушаалаар ерөнхий боловсролын сургууль, дээд боловсролын сургалтын байгууллагын төгсөгчдийн баримт тодорхойлолтыг Төрийн үйлчилгээний цахим /ГҮЦ/ машинаас олгох журам, тодорхойлолтын загварыг тус тус баталсан.</p> <p>Мөн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны А/156 тоот тушаалаар ерөнхий боловсролын сургуулийн Суурь, бүрэн дунд боловсрол эзэмшигчдэд боловсролын баримт бичиг олгох, дүйцүүлэх журам батлагдсан. Үүний дагуу 2018-2019 хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуулийн боловсролын баримт бичгийг Боловсролын салбарын мэдээллийн</p>
---	--	--	-----------	---

системээс хэвлэж олгосон бөгөөд, лавлагааг системээс вебээр болон гар утсаны аппликешнаар дамжуулан олгодог болоод байна.

Тодорхойлолтын мэдээллийг ХУР системтэй цахим сервисээр солилцох зориулалт бүхий серверийг Үндэсний дата төвд байрлуулан тус төвтэй гэрээ байгуулсны үндсэн дээр 2019 онд олгогдсон суурь боловсролын гэрчилгээ болон бүрэн дунд боловсролын үнэмлэхний тодорхойлолтыг 2019 оны 08 дугаар сараас ТҮЦ машинаас олгож эхлээд байна. Мөн 2016-2018 онд дээд боловсролын сургалтын байгууллагаас төгсөгчиддөө олгосон дипломын мэдээллийн санг бүрдүүлэн Үндэсний дата төвд байрлах өөрийн сервер дээр байрлуулсан. Тус төвөөс ХУР системтэй цахим сервисээр мэдээлэл солилцох хөгжүүлэлтийн ажлыг эхлүүлсэн ба 2019 оны 11 дүгээр сараас дээд боловсролын сургалтын байгууллагын дипломын тодорхойлолтыг ТҮЦ машинаас олгож эхлээд байна.

Ерөнхий боловсролын сургалтад цахим журнал хөтлөх талаар авах арга хэмжээний тухай Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны А/499 тоот тушаал батлагдсантай холбоотойгоор боловсролын салбарын мэдээллийн системд зохих хөгжүүлэлтийг хийж ерөнхий боловсролын сургуулийн багш, анги удирдсан багш, сургалтын менежер, удирдлага, цахим журналыг вебээр болон гар утсаны аппликешнаар хөтлөх боломжийг бүрдүүлсэн. Мөн цахим журнал хөтөлж буй ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын эцэг, эх,

11	<p>4.1.2.4.эрсдэлд суурилсан төрийн хяналт шалгалт болон аж ахуйн нэгжийн дотоод хяналтыг бэхжүүлэх, хяналт шалгалтын 70 хувийг урьдчилан зорилгоор байгуулах, чиглэлийг замаар хяналт шалгалтын тогтолцоог боловсронгуй болгох</p>	<p>Хяналт шалгалтын 70 хувийг урьдчилан сэргийлэх зорилгоор зохион байгуулах, хяналт шалгалтын чиглэлийг цөөрүүлэх</p>	<p>2018-2022</p>	<p>асран хамгаалагч нь өөрийн хүүхдийн ирц, дун, хичээлийн явцын талаар дэлгэрэнгүй мэдээлэл, сургуулийн талаар мэдээллийг вебээр болон гар утсаны аппликешнаар авах боломжийг бүрдүүлсэн. Мөн шинээр хөгжүүлсэн болон сайжруулсан модуль, цахим журнал хөтлөх гарын авлагуудыг бэлтгэн видео хичээл хэлбэрээр боловсруулж систем дээр байршууллаа.</p>
				<p>1.Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны харъяа Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Биеийн тамир, спортын газраас Үндэсний шигшээ багийн үйл ажиллагаанд гэрээний дагуу санхүүжилт олгосон 16 спортын төрлийн спортын холбоодын 2019 оны санхүүгийн үйл ажиллагаанд хэсэгчилсэн дотоод аудит, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, Төсвийн тухай хууль, Биеийн тамир, спортын тухай хууль, “Улсын төсвөөс дэмжлэг үзүүлэх үндэсний шигшээ багийг бүрдүүлэх, спортын төрлийг сонгох, санхүүжүүлэх журам” болон бусад хууль, тогтоомжийн хүрээнд гэрээний дагуу санхүүжүүлсэн ажлын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, илэрсэн зөрчлийг арилгуулах, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар дүгнэлт, санал боловсруулахад хяналт-шинжилгээ, үнэлгээг хийсэн./тайланг хавсаргав/</p> <p>2. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны харъяа Дүрслэх урлагийн музейн үйл ажиллагаанд Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, 7.4 дэх хэсгийг тус тус</p>

12	4.1.2.7. төрийн үйлчилгээний чанар, хүртээмжид хөндлөнгийн үнэлгээ хийх, албан хаагчийн үйл ажиллагааг иргэн үнэлэх тогтолцоог нэвтрүүлэх	Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжид хөндлөнгийн үнэлгээ хийлгүүлэх	2017-2022	<p>үндэслэн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн А/182 дугаар “Ажлын хэсэг байгуулах тухай” тушаалаар баталсан “Дүрслэх урлагийн музейн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийх ажлын удирдамж”-ийн хүрээнд хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийсэн. /тайланг хавсаргав/</p> <p>3.Нийслэлийн ерөнхий боловсролын лаборатори 28 дугаар сургуулийн үйл ажиллагаанд Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын баталсан 2019 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн ажлын хэсэг байгуулах тухай А/330 тоот тушаалын хавсралтаар батлагдсан удирдамжийн хүрээнд дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалт, хяналт-шинжилгээ үнэлгээ хийж дүнг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд болон тус байгууллагын удирдлагад танилцуулах, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангаж, зөрчлийг арилгах, тухайн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэх, мэргэжил арга зүйн зөвлөгөө, өгөх, хариуцлагыг сайжруулахад хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийсэн. /тайланг хавсаргав/</p> <p>Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын баталсан 2019 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн ажлын хэсэг байгуулах тухай А/183 тоот тушаалын хавсралтаар батлагдсан удирдамжийн хүрээнд “Үндэсний урлагийн их театр”-ын үйл ажиллагаанд дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалт, хяналт-шинжилгээ үнэлгээ хийж дүнг Боловсрол, соёл, шинжлэх</p>
----	---	--	-----------	--

13	<p>4.1.3.2.Төсвийн төлөвлөлтийн ашигтай байдал, гүйцэтгэл, зарцуулалтын хөндлөнгийн хяналт, хариуцлагыг дээшлүүлэх</p>	<p>Эрсдэлтэй гэж үзсэн төсөвт байгууллагын төсвийн зарцуулалтад санхүүгийн хөндлөнгийн хяналт хийх</p>		<p>ухаан, спортын сайд болон тус байгууллагын удирдлагад танилцуулах, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангаж, зөрчлийг арилгах, тухайн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэх, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, хариуцлагыг сайжруулахад хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын зорилгоор хяналт шалгалтыг хийсэн.</p>
			2017-2022	<p>1.Боловсрол, соёл, шинжлэх ухаан спортын сайдын 2019 оны 8 дугаар сарын 29 ны өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” А/537 тоот тушаалаар баталсан удирдамжийн хүрээнд “Спортыг дэмжих сан”-гийн 2019 оны эхний 10 сарын байдлаар дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалт хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж эрсдэлийн удирдлагаар хангаж зөрчлийг арилгуулах, зөвлөгөө өгөх, санхүүгийн үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгсөн. /тайланг хавсаргав/</p> <p>2. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын баталсан 2019 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн ажлын хэсэг байгуулах тухай А/538 тоот тушаалын хавсралтаар батлагдсан удирдамжийн хүрээнд “Соёл, урлагийг дэмжих сан”-гийн 2019 оны эхний 10 сарын байдлаар дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалт, хяналт-шинжилгээ үнэлгээ хийж дүнг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд болон тус байгууллагын удирдлагад танилцуулах, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангаж, зөрчлийг арилгах, тухайн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэх, мэргэжил арга зүйн зөвлөгөө, өгөн ажиллаа. . /тайланг хавсаргав/</p>

14	4.1.3.3. Засгийн газрын тусгай сангийн санхүүжилт, зарцуулалтыг ил тод, хяналттай болгох	Засгийн газрын тусгай сангийн санхүүжилт, зарцуулалтын мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд “ЗГ-ЫН тусгай сангийн мэдээлэл” гэсэн цэсээр олон нийтэд мэдээлэх ажлыг зохион байгуулах	2017-2019	<p>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын төсвийн ерөнхийлөн захирагчийн шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийг Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын дагуу www.mecss.gov.mn/, www.shilendans.gov.mn байршуулан ажилласан.</p> <p>Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарын Төсвийн ерөнхийлөн захирагчийн Шилэн дансны мэдээллийн хувьд:</p> <p>Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1-д заасан мэдээлэл буюу Тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг хуулийн хугацаанд байршуулсан болно.</p> <p>Мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2-д заасан мэдээлэл буюу өмнөх оны төсвийн гүйцэтгэл, сар, улирлын төсвийн гүйцэтгэлүүдийг хуулийн хугацаанд нь байршуулан ажилласан болно.</p> <p>Тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4-д заасан мэдээлэл буюу жилийн эцсийн санхүүгийн тайлан болон хагас жилийн тайланг PDF хэлбэрээр Шилэн дансны цахим хуудасд байршуулан ажиллаа. Мөн тус хуульд заасан Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлтийг цахимд байршуулан ажилласан. Хуульд заасан бусад мэдээлэлүүдийг цаг тухай бүрт нь Шилэн дансны цахим санд 7 хоног бүр нийтэд мэдээллэх мэдээлэлүүдийг тухай бүрт нь байршуулан ажиллаа. Үүнд:</p> <p>Тайлант хугацаанд таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил</p>
----	--	--	-----------	--

үйлчилгээг нийтэд мэдээллэсэн нийт гүйлгээний тоо 855 байна.

Нийт 119 төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр авлага үүсгэсэн тушаал шийдвэрийг Шилэн дансны цахим санд байршуулсан.

Харьяа байгууллагуудын шилэн дансны үйл ажиллагааны 2018 оны тайланг урьдчилсан байдлаар нэгтгэн боловсруулж Үндэсний аудитын газарт цахимаар хүргүүлсэн.

Тайланд Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарын 60 байгууллага хамрагдсан. Үүнээс: Шилэн дансны тухай хуулийн дагуу нийтэд мэдээллэх нийт 28 мэдээллийг 48 байгууллага хугацаандаа, 12 байгууллага хугацаа хоцроож мэдээллэсэн байна. Харин 5 сая төгрөгөөс дээш худалдан авалтын тоо нийт 354 буюу 5.2 тэрбум төгрөг, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээний тоо нийт 3287 буюу 130.6 тэрбум төгрөг, орлогын мөнгөн гүйлгээ 821 буюу 346.6 тэрбум төгрөг мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь заалт буюу бонд, Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийн тоо 1813 буюу 17.5 тэрбум төгрөгийг тус тус Шилэн дансны нэгдсэн цахим хуудас www.shilendans.gov.mn байршуулсан байна.

2019 оны улсын төсөвт соёл урлагийн салбарын байгууллагуудын өөрийн орлогыг тэглэж 100 хувь улсын төсвөөс санхүүжүүлэхээр болсон бөгөөд соёл урлагийн байгууллагуудын өөрийн үйл ажиллагаанаас олсон орлогыг тухайн

байгууллагад зарцуулах эрхгүйн зохицуулалт шаардлагатай болсон. Энэхүү ажлын хүрээнд “Соёл урлагийн байгууллагын орлогыг зарцуулах журам”-ын төслийг боловсруулж Сангийн яаманд хүргүүлж, Сангийн сайдын 2019 оны 74 дүгээр тушаалыг батлуулснаар Соёл урлагийн байгууллага нь үйл ажиллагааны орлогыг нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулж хүсэлт гаргасан даруй тухай бүр зарцуулж байхаар шийдвэрлэсэн. Уг журмаар байгууллага олсон орлогоо дээрх журмын хүрээнд зарцуулах эрхтэй болсон. Соёл урлагийн салбарын улсын төсвийн нийт 19 байгууллагаас 16 байгууллага 2019 оны эхний 10 сарын дүнгээр нийт 3.1 тэрбум төгрөгийн орлого бүрдүүлсэн байна. Нийт орлогын 62 хувийг хамгийн их орлоготой 5 байгууллага бүрдүүлсэн үүнээс хамгийн их буюу 689.7 сая төгрөгийн орлогыг Үндэсний түүхийн музей бүрдүүлсэн байна. Ингэснээр соёл урлагийн байгууллагууд шаардлагатай эд хогшил, тоног төхөөрөмж худалдан авах, байгууллагын хамт олон, ажилтныг ажлын үр дүнг харгалзан урамшуулах, нийт ажилтны нийгмийн асуудлыг шийдвэрлэх зэрэг төсвийн дутагдаж байгаа эх үүсвэрийг бүрүүлж, үндсэн үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлж, улсын төсвөөс хамааралгүй өөрсдийн эх үүсвэрээр төсвийн тодорхой хувийг санхүүжүүлж байгаагаараа санхүүгийн үр өгөөжийг нэмэгдүүлж, анх удаа салбарын өөрийн үйл ажиллагааны орлогыг 2 дахин нэмэгдүүлж ажилласан байна.

15		<p>Тусгай сангийн хөрөнгийг захиран зарцуулах шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах, иргэд олон нийтийн зүгээс хяналт тавих боломжийг нээх</p>	2017-2020	<p>Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын дагуу Боловсролын зээлийн сан, Шинжлэх ухаан технологийн сан, Спортыг дэмжих сан, Соёл, урлагыг дэмжих сан, Кино урлагийг дэмжих сан/шинээр байгуулагдсан/-ын тусгай сангийн хөрөнгийг захиран зарцуулах шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах, иргэд олон нийтийн зүгээс хяналт тавих боломжийг нээн www.mecss.gov.mn www.shilendans.gov.mn цахим санд тогтмол байршуулж байна.</p>
16	<p>4.1.7.3. Төрийн байгууллага, түүний удирдлагын үйл ажиллагаанд төрийн бус байгууллага хяналт тавих боломжийг бий болгох, төрийн зарим ажил үйлчилгээг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх, санхүүжилтийг ил тод, үр ашигтай зарцуулах, түүнд хяналт тавих тогтолцоог бүрдүүлэх</p>	<p>Төрийн байгууллага, түүний удирдлагын үйл ажиллагаанд төрийн бус байгууллага хяналт тавих боломжийг бүрдүүлэх</p>	2017-2019	<p>Ерөнхий боловсролын сургуульд хэрэглэж байгаа I-XII ангийн бүх сурах бичгийг цахим хэлбэрээр www.meds.gov.mn веб хуудсанд байршуулж, хэрэглэгчдэд нээлттэй ашиглуулж байна. Мөн андройд, ios үйлдлийн системтэй төхөөрөмжөөр сурах бичгийг ашиглах аппликейшн бий болгосон. Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид сурах бичгийг тохиромжтой хэлбэрээр ашиглах боломжийг бий болгох чиглэлээр холбогдох төрийн бус байгууллагуудыг дэмжин хамтран ажиллаж байна. Харааны бэрхшээлтэй сурагчдад зориулан 1-3 дугаар ангийн сурах бичгийг брайль болон томруулсан үсгээр хослуулан хэвлэх талаар Монголын хараагүйчүүдийн үндэсний холбоо ТББ-тай, Ерөнхий боловсролын сургуулийн I-XII ангийн сурах бичгүүдийг DAISY E-pub хүртээмжит форматад шилжүүлж хараагүй болон харааны бэрхшээлтэй иргэд бусдын адил</p>

<p>ашиглах боломжтой болгох талаар “Хараагүй хүмүүсийн инноваци хөгжлийн төв” ТББ-тай хамтран ажиллаж байна.</p> <p>Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны А/582 дугаар тушаалаар “Өдөр өнжүүлэх үйлчилгээ эрхлэхэд тавих нийтлэг шаардлага”-ын төсөл боловсруулах ажлын хэсгийг холбогдох төрийн болон төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулан байгуулж, “Өдөр өнжүүлэх үйлчилгээ эрхлэхэд тавих нийтлэг шаардлага”-ыг боловсруулж, батлууллаа.</p> <p>Боловсрол, соёл, шижлэх ухаан спортын сайдын 2016, 2017 онуудад хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байсан бөгөөд 2019 оны 02 дугаар сарын 14-ны өдрийн А/71 дүгээр тушаалаар “Боловсролын хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах ажлын хэсэг”-ийг дахин шинэчлэн байгуулсан. Ажлын хэсгийн зүгээс дараах үйл ажиллагааг зохион байгуулсан</p> <p>Хуулийн үзэл баримтлалын төсөлд санал авахаар холбогдох төрийн бус байгууллага болон мэргэжлийн холбоодод хүргүүлээд байна. Ирүүлсэн саналыг нэгтгэн хуулийн төсөлд тусгахаар ажиллаж байна.</p> <p>Хууль зүй, дотоод хэргийн яамнаас хуулийн үзэл баримтлал батлагдан ирвэл холбогдох яамдын саналыг авч хуулийн төслийг УИХ хуралд өргөн барих бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.</p> <p>Шинжлэх ухаан, технологи инновацийн талаар төрөөс баримталж байгаа бодлого, дэлхийн болон Монголын шинжлэх ухаан, техник технологийн сүүлийн үеийн ололт, амжилтыг</p>			
---	--	--	--

17	<p>4.1.10.1.авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэхэд иргэн, төрийн болон төрийн бус байгууллагын оролцоог хангах арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх</p>	<p>Авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх зорилгоор иргэдэд зориулсан сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах</p>	2017-2022	<p>олон нийтэд өргөн сурталчлах, шинжлэх ухааны салбарт хийгдэж байгаа судалгаа шинжилгээний ажлын үр дүнг үйлдвэрлэлд түргэн шуурхай нэвтрүүлэх, дэлхийн шинжлэх ухааны төвүүдтэй хамтран ажиллахад тус дөхөм үзүүлэх зорилготой ашгийн бус шинжлэх ухааны сэтгүүлчдийн клуб төрийн бус байгууллагатай хамтран ажиллах төлөвлөгөөний төслийг боловсруулж байна.</p> <p>Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамнаас 2019 оныг “Иргэний ёс зүйн боловсролын жил” болгон зарлаж Авлигатай тэмцэх газартай хамтран “УРИАЛГА” гарган хамтран ажиллаж байна. /хавсралтаар уриалгыг хүргүүлэв/</p> <p>Мөн Авлигатай тэмцэх газрын 2019 оны 03/3631, 01/4296 дугаар албан бичгээр ирүүлсэн Зөвлөмжийг хэрэгжүүлэх зорилгоор Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн “Хөтөлбөр, төлөвлөгөө, зөвлөмжийг хэрэгжүүлэх зарим арга, хэмжээний тухай” А/373 дугаар тушаалаар Аймгийн боловсрол, соёлын газрын дарга нарт, Нийслэлийн боловсролын газрын дарга, Нийслэлийн соёл, урлагын газарт тус тус 2019 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 1а/5297, 1а/5298, 1а/5299 дугаар “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгийг хүргүүлсэн.</p>
----	---	--	-----------	--

19	<p>4.1.10.2.боловсролын байгууллага болон гэр бүлээр дамжуулан авлигыг үл тэвчих, шударга иргэнийг төлөвшүүлэх зорилгоор олон талт арга хэмжээ зохион байгуулах, авлигын эсрэг боловсрол олгох агуулгыг бүх шатны боловсролын байгууллагын сургалтын хөтөлбөр, стандартад тусгах</p>	<p>Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын агуулга, хичээлийн хөтөлбөрт шударга ёсны үзэл, хандлагыг бий болгох, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх асуудлыг тусгах</p>	2017-2022	<p>Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны “Хөтөлбөр батлах тухай” А/492 дугаар тушаалаар баталсан бага ангийн “Хүн ба нийгэм”, дунд, ахлах ангийн “Нийгэм судлал”, бага, дунд, ахлах ангийн “Иргэний ёс зүйн боловсрол” сургалтын хөтөлбөрт шударга ёс, авлигын талаарх агуулгыг тусган ерөнхий боловсролын нийт сургуулийн суралцагчид судалж байна. /Хавсралтаар 3 сурах бичиг хүргүүлэв/</p>
20	<p>Их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сэдвийг тусгах</p>	2017-2022	<p>Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан “Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн мэргэжилтэн бэлтгэх сургалтын хөтөлбөр батлан хэрэгжүүлэх” ажлын хүрээнд Үр дүнд суурилсан боловсролыг хөгжүүлэх бодлого /дээд боловсрол/-ыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны А/533 дугаар тушаалаар баталсан. Бодлогын баримт бичиг 4 зорилт дэвшүүлсэн. Үүнд: 1. Үр дүнд суурилсан боловсролын арга зүйн дагуу сургалтын хөтөлбөр боловсруулах үйл ажиллагааг чанаржуулах; 2. Оюутан төвтэй суралцахуйн үйлийг дэмжсэн сургалтын орчин,</p>	

21			<p>нөөц бүрдүүлэх, цахим сургалтын технологийн хэрэглээг нэмэгдүүлэх; 3.Их, дээд сургууль, коллежийн профессор, багш нарын мэргэжил, заах арга зүйн чадамжийг дээшлүүлэх; 4.Сургалтын чанар, үр дүнг хэмжих үнэлгээ, чанарын баталгаажуулалтын тогтолцоог хөгжүүлэх зэрэг болно.</p> <p>Энэхүү бодлого (Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны А/533 тушаал)-ын 4.1.6-д заасны дагуу дээд боловсролын сургалтын хөтөлбөрийн боловсруулалтад үнэлгээ хийж, санал, дүгнэлт боловсруулах ажлын хэсгийг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны 06 дугаар сарын 19-ны өдрийн А/405 дугаар тушаалаар байгуулан 60 их, дээд сургуулийн 536 бакалаврын хөтөлбөрт үнэлгээ хийж, сургууль бүрт чиглэл, зөвлөмжийг өгсөн. Ажлын хэсгийн 9 багийн тайланд хөтөлбөрийн ерөнхий 10 чиглэлээр дүн шинжилгээ хийн гарсан үр дүнг “CDIO-2019” эрдэм шинжилгээний 2019 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлээд байна.</p> <p>Хүний хөгжлийг хангах чиглэлээр 3 кредитийн “Хүний үндсэн эрх /шударга ёс, авлигаас урьдчилан сэргийлэх/, хувь хүний төлөвшил, хөгжлийн талаар суралцах, бүтээлч сэтгэлгээ, хувийн зохион байгуулалт, өөрийгөө хянах чадвар, багаар ажиллах чадвар, нийгэм, хүмүүнлэгийн үйл ажиллагаанд биечлэн оролцох, зохион байгуулах чадвар эзэмшүүлэх” хичээлийг оруулсан байгаа болно.</p>
		Оюутан, сурагч, эцэг, эхийг хамруулсан	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамнаас 2019 оныг “Иргэний ёс зүйн
			2017-2022

шударга ёсны сэдэвт өдөрлөг, сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулах

Боловсролын жил” болгон зарлаж Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Авлигатай тэмцэх газартай хамтран “УРИАЛГА” гаргасан.

Багш, сурган хүмүүжүүлэгчид, эрдэмтэн судлаачид, урлаг, соёлынхон, авьяастнууд, тамирчид, дасгалжуулагчид, соён гэгээрүүлэх салбарт хууль бус зүйл, ашиг хонжоо хайсан үйлдэл, ёс зүйгүй байдал огтхон ч байж болохгүй бөгөөд нийгэмд үзүүлж байгаа бүх талын үйлчилгээ маань хариуцлагатай, мэргэжлийн ёс зүйтэй байж, нийгэм олон түмнээ манлайлан ажиллахыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам болон Авлигатай тэмцэх газраас Та бүхэндээ уриалж байна.

Хүүхдийн өмнө хүлээсэн журамт үүргээ хүн бүр хичээн биелүүлцнээе... гэсэн утгатай уриалгыг гарган 2019 онд хамтран ажилласан болон тус яамны зүгээс зохион байгуулсан үйл ажиллагаануудын оролцогчч харъяа байгууллагын удирдагуудад хүргүүлсэн.

Авлигатай тэмцэх газраас Авлигын эсрэг олон улсын өдрийг угтан 2019 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр “UB PALACE”-ийн их танхимд их, дээд сургуулийн оюутнуудад зориулан зохион байгуулсан залуучууд зөв шударга байх, өв уламжлалаа дээдлэн эрхэмлэх, хадгалах түүчээлэх, үлгэр дуурайлал авах, эерэг зөв хандлага төлөвшүүлэх илтгэл, лекцэд харъяа байгуулагуудаас Соёл, урлагын их сургуулийн 200 гаруй оюутнууд оролцсон.

Мөн Авлигатай тэмцэх газраас 2019 оны 12 дугаар сарын 3-ны өдөр зохион байгуулсан “Боловсролын салбар дахь ёс зүйн асуудал” хэлэлцүүлэгт Соёл урлаг судлалын хүрээлэнгийн Соёлын секторын эрхлэгч

				М.Золзаая оролцож, "Монголчуудын үнэт зүйл" социологийн судалгааны үр дүнгээс танилцуулсан.
--	--	--	--	---

Танилцсан: Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр
гүйцэтгэгч, хуулийн хэлтсийн дарга

Л.Цэдэвсүрэн

Боловсруулсан: Хуулийн хэлтсийн мэргэжилтэн



Б.Мөнгөнбагана